

ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНИЙ НЭГТГЭЛ

Эрүүл Мэндийн Сайдын 2012 оны А/427 дугаар тушаал Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журмын дагуу 13 эрүүл мэндийн байгууллага хүлээгдлийн мэдээ ирүүлэхээс 2025 оны 7 дугаар сард 4 байгууллага тусламж, үйлчилгээний хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байна.

Нэг. УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

1. Тус эмнэлгээс ирүүлсэн мэдээллээс харахад нийт 13 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1.

Амбулаторийн үзлэгийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1.	Бөөр судлал	-	-	6	6
2.	Мэдрэл судлал	-	-	1	1
3.	Хоол боловсруулах эрхтэн судлал	1	-	-	1
4.	Нүд судлал	-	-	3	3
5.	Хэрх үе судлал	-	-	2	2
	Нийт	1	-	12	13

2. 2025 оны 7 сард тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй буюу нийт 2585 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн орны хүлээгдэлтэй байна. Нүд, Чих, хамар, хоолой, Урологи, Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр иргэд хамгийн их хүлээж байна. Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1348 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн тал хувийг эзэлж байна. Мөн хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн 79.8% нь 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1.	Нүд судлал	40	40	130	1138	1348
2.	Чих, хамар, хоолой судлал	-	9	20	910	939
3.	Урологи	50	26	36	10	122
4.	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	26	11	83	-	120
5.	Хоол боловсруулах эрхтэн судлал	4	3	7	6	20
6.	Цусны эмгэг судлал	17	1	-	-	18
7.	Мэс засал судлал	2	-	13	-	15
8.	Мэдрэл судлал	2	-	-	-	2
9.	Уушги судлал	1	-	-	-	1
	Нийт	142	90	289	2064	2585

3. Оношилгооны чиглэлээр КТГ шинжилгээ хийлгэхээр нийт 230 хүн 7-14 хоног, MRI шинжилгээ хийлгэхээр 40 үйлчлүүлэгч 15 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3.

Оношилгооны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа					Бүгд
		Өдөртөө	1-3 хоног	3-6 хоног	7-14 хоног	15 ба түүнээс дээш	
1	MRI	-	-	-	-	40	40
2	Ходоодны дуран	-	10	20	50	-	80
3	КТГ	-	72	36	180	-	288
	Нийт	-	82	56	230	40	408

Хоёр. ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

1. Гэмтэлийн нарийн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 287 үйлчлүүлэгч 3-аас дээш хоног хүлээж байна. Хүүхдийн мэс заслын эмчид үзүүлэхээр 52, насанд хүрэгсдийн мэс заслын эмчид үзүүлэхээр 49, гар сарвууны мэс заслын эмчид үзүүлэхээр 43 үйлчлүүлэгч тус тус хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Өмнөх сарын хүлээгдэлтэй харьцуулвал буурсан үзүүлэлттэй байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4

Амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1.	Хүүхдийн мэс засал	20	20	12	52
2.	Гар сарвууны бичил мэс засал	39	5	5	49
3.	Насанд хүрэгсдийн мэс засал	28	9	6	43
4.	Сэргээн засах эмчилгээ	3	1	25	29
5.	Нурууны мэс засал	1	1	26	28
6.	Ясны эмгэгийн мэс засал	15	1	2	18
7.	Спортын гэмтлийн мэс засал	5	1	8	14
8.	Нөхөн сэргээх мэс засал	13	1	-	14
9.	Толгойн мэс засал	10	1	-	11
10.	Түлэнхий, нөхөн сэргээх мэс засал	8	-	-	8
11.	Хавсарсан гэмтлийн мэс засал	6	-	-	6
12.	Чих хамар хоолойн мэс засал	6	-	-	6
13.	Зүрх судасны эмчийн үзлэг	4	1	-	5
14.	Нүүр амны мэс засал	3	-	-	3
15.	Амбулаторийн эмчийн үзлэг	-	1	-	1
16.	Нүдний мэс засал	-	-	-	-
	Нийт	161	42	84	287

2. MRI оношилгоонд хамрагдахаар 122, Рентген -83, КТГ-30, Хэвлийн эход харуулахаар 6 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Хэвлийн эхо оношилгооны хүлээгдэл өмнөх сараас буурсан үзүүлэлттэй байна. (Хүснэгт 5)

Хүснэгт 5.

Оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа				Нийт
		Өдөртөө	3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1.	Хэвлийн эхо	6	-	-	-	6
2.	КТГ	26	4	-	-	30
3.	Рентген зураг	83	-	-	-	83
4.	MRI	11	1	110	-	122
	Бүгд	126	5	110	-	241

3. Хэвтэн эмчлүүлэх тасагт үйлчлүүлэхээр 21 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Сэргээн засах эмчилгээний тасгийн хүлээгдэл энэ сард нэмэгдэж, гар сарвууны бичил мэс засал, насанд хүрэгсдийн мэс засал, толгойн мэс заслын тасгууд хүлээгдэлгүй ажилласан байна. (Хүснэгт 6)

Хүснэгт 6.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1.	Нүдний мэс засал	1	-	-	1
2.	Хүүхдийн мэс засал	2	1	-	3
3.	Толгойн мэс засал	-	-	-	-
4.	Сэргээн засах эмчилгээ	8	-	-	8
5.	Ясны эмгэгийн мэс засал	2	1	-	3
6.	Спортын гэмтлийн мэс засал	2	1	-	3
7.	Түлэнхий, нөхөн сэргээх мэс засал	1	-	-	1
8.	Насанд хүрэгсдийн мэс засал	-	-	-	-
9.	Нөхөн сэргээх мэс засал	2	-	-	2
10.	Гар сарвууны бичил мэс засал	-	-	-	-
	Нийт	18	3	-	21

Гурав. АРСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

1. Арьс, гоо заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр тус бүр 42 үйлчлүүлэгч 1-6 хоног, харин харшлын тасагт хэвтэж эмчлүүлэхээр 21 үйлчлүүлэгч 1-3 хоног хүлээж байна. (Хүснэгт 7)

Хүснэгт 7.

Хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		1-3 хоног	3-6 хоног	7-14 хоног	
1.	Арьс судлал	35	7	-	42
2.	Гоо засал судлал	28	14	-	42
3.	Харшил судлал	21	-	-	21

	Нийт	84	21	-	105
--	------	----	----	---	-----

- 7 дугаар сард Амбулатори, Оношилгоо, Лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй ажилласан байна.

Дөрөв. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

1. 2025 оны 7 сард Оношилгооны хүлээгдэлгүй ажилласан байна. Амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 70 үйлчлүүлэгч хүлээж байгаа ба 37 буюу тал хувь нь 3-аас дээш хоногийн хүлээгдэлтэй байна. (Хүснэгт 8)

Хүснэгт 8.

Амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо					Нийт
		Өдөртөө	1 хоног	2 хоног	3-6 хоног	7-14 хоног	
1	Эмгэг судлал	30	2	1	4	33	70

2. Хэвтэн эмчлүүлэхээр нийт 60 үйлчлүүлэгч 15-30 хоног хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн 81 хувийг эзлэж байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	
1	Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлал	-	10	60	74

- 7 дугаар сард Оношилгоо болон Лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй ажилласан байна.
4. 7 дугаар сард Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2, Хүүхдийн төв сувилал, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Геронтологийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.
5. 6 дугаар сард хүлээгдлийн мэдээ ирүүлээгүй Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2, Хүүхдийн төв сувилал, Нийслэлийн эрүүл мэндийн газар руу хүлээгдлийн мэдээг ЭМС-ын 2012 оны А/427 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган, хамтран ажиллах албан бичиг боловсруулан илгээсэн.

ЭМХТ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН АЛБА